



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Г Гадаадад зээлээр суралцуулах,  
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чинзориг овогтой Дэлгэрмааг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар Австрали Улсын Southern Cross их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1,5 жилийн хугацаагаар, Раш овогтой Оргилмааг Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар АНУ-ын Арканзасын улсын их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 317 дугаар тушаалын Баасанжав овогтой Оюунцэцэгтэй холбогдолтой хэсгийн “АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт” гэснийг “БНСУ-ын Solbridge Бизнесийн олон улсын сургуулийн магистрантурт” гэж өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан 2008 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 351 дүгээр тушаалын 2 дахь заалт болон 2007 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 334 дүгээр тушаалын Харцага овогтой Чинзоригтой холбогдолтой хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР